

БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД, БАЙНГЫН
АЖИЛЛАГААТАЙ ДЭД ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Х.ГАНХУЯГ

2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр

ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БАЙНГЫН
АЖИЛЛАГААТАЙ ДЭД ЗӨВЛӨЛИЙН 2026 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Арга хэмжээний чиглэл, нэр	Хугацаа	Хариуцах байгууллага
Нэг. Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох			
1.1	Барилга байгууламжийн газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх, хүчитгэх ажлыг зохион байгуулахтай холбоотой хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх санал боловсруулж хэрэгжүүлэх	Жилд	ХББОСЯ
1.2	Барилгын үндсэн хийц, бүтээцийн бэхэлгээ, хүчитгэлийн техникийн шийдлийг боловсруулах, батлах (Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл-2)	Жилд	ХББОСЯ, ОБЕГ
1.3	Газар хөдлөлийн чиглэлийн норм, норматив баримт бичгийг шинэчлэх, шинээр боловсруулах	Жилд	ХББОСЯ
Хоёр. Урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах			
2.1	Булган, Говь-Алтай, Завхан, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураг хийх, инженер-геологи, гидрогеологийн судалгааны ажлын үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлэх	II, III улирал	СЯ, ХББОСЯ, ГЗБГЗЗЕГ, ООГХ
2.2	Онцгой байдлын байгууллагын Гал түймэр унтраах, аврах ангийн барилга байгууламжид газар хөдлөлтөд тэсвэржилтийн үнэлгээ хийж, паспортжуулах	III, IV улирал	Аймаг, нийслэлийн ЗД, НОБГ
2.3	Гамшгийн аюулын зарлан мэдээллийн системийн бэлэн байдлыг хангах, шаардлагатай техник, хэрэгслийн судалгаа, тооцоог боловсруулан танилцуулж, шийдвэрлүүлэх, хүн амд шуурхай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх	Жилд	ЦХИХХЯ, ОБЕГ, Аймгийн ЗД
2.4	Газар хөдлөлтөөс үүсэх хөрсний чичирхийллийн хурдатгал хэмжигч багажийг аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт суурилуулах, шаардлагатай хөрөнгийг гаргах	Жилд	СЯ, аймаг, нийслэлийн ЗД, ООГХ, НОБГ
2.5	Нийслэлийн Гамшгаас хамгаалах албадад бэлэн байдлын үзлэг зохион байгуулах	Жилд	НЗД, НОБГ
2.6	Газар хөдлөлт бүртгэх станц болон амжиж анхааруулах системийн станцуудын сэлбэг хэрэгслийн зардлыг шийдвэрлэх	II, III улирал	СЯ, ЭЗХЯ
2.7	Улсын хэмжээнд ашиглагдаж буй 2002 оноос өмнө ашиглалтад орсон болон ашиглалтын шаардлага хангахгүй сургууль, цэцэрлэг, эмнэлэг, дотуур байрны барилга, байгууламжийг паспортжуулах, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх	Жилд	ХББОСЯ, БЯ, ЭМЯ, Аймаг, нийслэлийн ЗД

2.8	Монгол орны баруун монголын зарим бүс (Монгол Алтай Нууруудын хотгор, Төв Монголын массив)-ийн шатах ашигт малтмалын хэтийн төлөвийн судалгаа чиглэлээр хийгдсэн судалгааны баруун Монголын тектоник структурын суурь судалгааны материалын үр дүнг нэгтгэн мэдээлэл бүрдүүлэх	III, IV улирал	УГА
Гурав. Бэлэн байдлыг дээшлүүлэх			
3.1	Болзошгүй гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх, түр цугларах талбай, түр байрыг томилгоожуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, бэлэн байдлыг хангуулах	Жилд	Аймаг нийслэлийн ЗД, ОБЕГ
3.2	Эм, эмнэлгийн хэрэгсэл, цус, цусан бүтээгдэхүүний нөөц, эрсдэлийн сан бүрдүүлэх, сайн дурын донорын тоог нэмэгдүүлэх	Жилд	ЭМЯ, МУЗН
3.3	Газар хөдлөлтийн гамшгийн үед хэрэглэх хүнс, бараа материалын нөөцийн мэдээллийг улсын хэмжээнд гаргах	Жилд	ХХААХҮЯ, Аймаг, нийслэлийн ЗД
3.4	Гамшгийн үед анхан шатны нийгэм, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх сайн дурын идэвхтэн, улаан загалмайн ажилтнуудыг бэлтгэх, мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхыг сайжруулах сургалт зохион байгуулах	Жилд	ЭМЯ, МУЗН
3.5	Сүхбаатар аймгийн Дарьганга сумын (SUA2) станцын эх хавтанг солих, Хэнтий аймгийн Батширээт сумын (HEA2) станцын эрчим хүч, өгөгдөл дамжуулалтыг шинэчлэх	Жилд	ГЗБГЗЗЕГ
3.6	Радио өргөн нэвтрүүлгийн их чадлын станцуудад нарны сэргээгдэх эрчим хүчний систем нэвтрүүлж, газар хөдлөлтийн гамшгийн үеийн эрчим хүчний найдвартай байдлыг хангах	Жилд	ЦХИХХЯ, ЭХЯ, РТҮС
Дөрөв. Гамшгаас хамгаалах сургалт, дадлага			
4.1	“Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр”, гамшгийн аюулыг зарлан мэдээлэх дохиогоор ажиллах дадлага сургуулийг улсын хэмжээнд зохион байгуулах	I улирал	Аймаг, нийслэлийн ЗД, ОБЕГ
4.2	Бүх шатны боловсролын байгууллагад газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлийн сургалт, дадлага, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	Жилд	БЯ, ОБЕГ
4.3	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн улсын алба, Баянхонгор, Сүхбаатар аймагт гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулах, эрчим хүчний улсын алба, эрүүл мэнд, сурталчилгааны улсын албанд хамтарсан гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг зохион байгуулах	Жилд	ЗТЯ, АҮЭБЯ, ЭХЯ, ОБЕГ
4.4	Увс аймагт “Говийн чоно” болон “Хааны эрэлд” олон улсын дадлага сургууль, Говьсүмбэр аймагт гамшгаас хамгаалах команд штабын сургууль, Архангай, Дундговь аймагт гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль тус тус зохион байгуулах	Жилд	Аймгийн ЗД, ОБЕГ
4.5	Газар хөдлөлт тэсвэрлэлтийг хангах барилгын хүчитгэлийн үйл ажиллагааг зохион байгуулах заавар, хоргодох байраар ашиглах сургууль, цэцэрлэгийн төлөвлөлтийн талаар сургалт зохион байгуулах	Жилд	ХББОСЯ

Тайлбар:

• АҮЭБЯ	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам;
• АЗД	Аймгийн Засаг дарга;
• БАДЗ	Байнгын ажиллагаатай дэд зөвлөл;
• БЯ	Боловсролын яам;
• ГЗБГЗЗЕГ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар;
• ЗТЯ	Зам, тээврийн яам;
• НЗД	Нийслэлийн Засаг дарга;
• ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар;
• ООГХ	Одон орон, геофизикийн хүрээлэн;
• РТҮС	“Радио телевизийн үндэсний сүлжээ”
• ССАЖЗЯ	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам;
• СЯ	Сангийн яам;
• ҮГА	Үндэсний геологийн алба
• ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам;
• ХББОСЯ	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам;
• ЦХИХХЯ	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
• ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам
• ЭМЯ	Эрүүл мэндийн яам
• ЭХЯ	Эрчим хүчний яам

БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ ДЭД ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА